

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/218/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Өлгий хот	Аудитын менежер: Х.Женисбек
2024 он	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Р.Баярмаа Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт	17
Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
А.СЕРИКБОЛАТ ТАНАА

2024.02.22 № 167
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402250

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЖАЙГУЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,335,551.00</u>	<u>7,335,551.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	7,335,551.00	7,335,551.00
354	Хангамжийн материал	7,335,551.00	7,335,551.00
35410	Бичиг хэргийн материал	5,100.00	5,100.00
35420	Аж ахуйн материал	7,330,451.00	7,330,451.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,807,087.12</u>	<u>43,454,181.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,807,087.12	43,454,181.84
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	15,763,337.12	43,454,181.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,837,203.28	3,837,203.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,023,254.40	-1,279,068.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	180,000,000.00	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-180,000,000.00	-5,833,333.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,310,250.00	27,684,450.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,931,445.64	-12,900,812.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,304,895.00	40,288,175.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,734,311.12	-28,342,432.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	500,000.00	0.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	0.00
393	Биет бус хөрөнгө	43,750.00	0.00
39301	Програм хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-806,250.00	-850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>23,142,638.12</u>	<u>50,789,732.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>0.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>23,142,638.12</u>	<u>50,789,732.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	23,142,638.12	50,789,732.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	158,734,618.96	158,734,618.96
51101	Өмч: - төрийн	158,734,618.96	158,734,618.96
512	Хуримтлагдсан үр дүн	-135,591,980.84	-107,944,886.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-145,157,669.24	-117,510,574.52
51220	Тайлант үеийн үр дүн	9,565,688.40	9,565,688.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>23,142,638.12</u>	<u>50,789,732.84</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,310,238,300.00	1,330,629,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	24,800,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	22,200,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	22,200,000.00
122	Тусламжийн орлого	-	2,600,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	2,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,310,238,300.00	1,305,829,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	769,052,500.00	651,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	769,052,500.00	651,700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	541,185,800.00	654,129,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	541,185,800.00	654,129,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,310,247,495.07	1,302,982,005.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,310,247,495.07	1,302,982,005.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,305,209,451.13	1,302,735,526.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,100,646.81	298,012,655.94
210101	Үндсэн цалин	128,345,437.53	193,739,254.71
210102	Нэмэгдэл	31,364,909.28	71,716,800.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,390,300.00	12,617,514.66
210104	Урамшуулал	-	19,939,086.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,774,198.81	37,060,965.54
210201	Тэтгэврийн даатгал	14,030,407.80	25,472,160.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,269,855.23	2,961,015.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,119,730.39	2,368,813.86
210204	Ажилгүйдлийн даатгал	305,155.25	568,996.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,049,050.14	5,689,978.74
2104	Хангамж, бараа материалын зардал	26,086,943.00	29,476,000.00
210401	Бичиг хэрэг	723,000.00	3,000,000.00

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	22,811,600.00	23,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,552,343.00	2,976,000.00
2105	Нормативт зардал	710,000.00	1,024,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	710,000.00	1,024,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	48,146,720.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	6,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	42,146,720.00
2107	Томилолт, зочны зардал	7,878,800.00	14,500,000.00
210702	Дотоод албан томилолт	7,878,800.00	14,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,562,500.00	8,957,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,562,500.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	135,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,076,096,362.51	865,558,185.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,067,240,000.00	845,714,025.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,081,700.00	6,579,975.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,774,662.51	13,264,185.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,038,043.94	246,478.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,666,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,371,343.94	246,478.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,371,343.94	246,478.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(9,195.07)	27,647,094.62
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(9,195.07)	27,647,094.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,310,238,300.00</u>	<u>1,305,829,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,310,238,300.00	1,305,829,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	769,052,500.00	651,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	769,052,500.00	651,700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	541,185,800.00	654,129,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	541,185,800.00	654,129,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,303,793,300.00</u>	<u>1,289,717,820.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,303,793,300.00	1,289,717,820.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,298,755,256.06	1,289,471,341.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,052,817.83	298,012,655.94
210101	Үндсэн цалин	125,844,755.66	194,485,411.18
210102	Нэмэгдэл	32,817,762.17	71,716,800.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,390,300.00	12,617,514.66
210104	Урамшуулал		19,192,929.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,142,495.23	37,060,965.44
210201	Тэтгэврийн даатгал	13,294,568.74	25,472,165.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,229,381.19	2,961,010.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	983,264.92	2,426,492.21
210204	Ажилгүйдлийн даатгал	239,789.15	511,318.40
210205	Эрүүл мэндийн даатгал	2,395,491.23	5,689,978.74
2104	Хангамж, бараа материалын зардал	26,086,943.00	29,500,000.00
210401	Бичиг хэрэг	723,000.00	3,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,811,600.00	23,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,552,343.00	3,000,000.00
2105	Нормативт зардал	710,000.00	1,024,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	710,000.00	1,024,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	48,146,720.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		6,000,000.00

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	10,000,000.00	42,146,720.00
2107	Томилолт, зочны зардал	7,878,800.00	14,500,000.00
210702	Дотоод албан томилолт	7,878,800.00	14,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,562,500.00	8,957,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,562,500.00	5,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		135,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,072,321,700.00	852,270,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,067,240,000.00	841,970,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,081,700.00	10,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,038,043.94	246,478.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,666,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,371,343.94	246,478.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,371,343.94	246,478.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>6,445,000.00</u>	<u>16,111,280.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>6,445,000.00</u>	<u>16,111,280.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>6,445,000.00</u>	<u>16,111,280.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	6,445,000.00	16,111,280.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,445,000.00	16,111,280.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-6,445,000.00</u>	<u>-16,111,280.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	-135,739,252.41	32,561,054.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	-135,739,252.41	32,561,054.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-9,409,261.76	-9,409,261.76
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-9,155.07	-9,155.07
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	-145,157,669.24	23,142,638.12
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	-145,157,669.24	23,142,638.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	-145,157,669.24	23,142,638.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			27,647,094.72	27,647,094.72
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	-117,510,574.52	50,789,732.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	654,129,100.00	653,882,621.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	654,129,100.00	653,882,621.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	654,129,100.00	653,882,621.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,134,300.00	298,012,655.94
210101	Үндсэн цалин	196,739,500.00	194,485,411.18
210102	Нэмэгдэл	87,764,800.00	71,716,800.57

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,630,000.00	12,617,514.66
210104	Урамшуулал		19,192,929.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,185,800.00	37,060,965.44
210201	Тэтгэврийн даатгал	25,168,400.00	25,472,165.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,254,300.00	2,961,010.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,603,500.00	2,426,492.21
210204	Ажилгүйдлийн даатгал	650,900.00	511,318.40
210205	Эрүүл мэндийн даатгал	6,508,700.00	5,689,978.74
2104	Хангамж, бараа материалын зардал	29,499,800.00	29,500,000.00
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,499,800.00	23,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,000,000.00
2105	Нормативт зардал	1,024,000.00	1,024,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,024,000.00	1,024,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,000,000.00	56,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	44,000,000.00	44,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,500,200.00	14,500,000.00
210702	Дотоод албан томилолт	14,500,200.00	14,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,957,000.00	8,957,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,000.00	135,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,828,000.00	208,828,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	198,528,000.00	198,528,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,300,000.00	10,300,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	654,129,100.00	653,882,621.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	654,129,100.00	653,882,621.38
132001	Орон нутгийн төсвөөс	654,129,100.00	653,882,621.38
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10.00	14.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	4.00	6.00

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	769052500.00	651,700,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	769052500.00	651,700,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769052500.00	651,700,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	952500.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	952500.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	768100000.00	651,700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	768100000.00	651,700,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	769052500.00	651,700,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	769052500.00	651,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	769052500.00	651,700,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Монгол Улсын Үндсэн хууль Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавхыг дээшлүүлэн иргэдийн төлөөллөөрөө дамжуулан нутаг дэвсгэрийнхээ иргэдийнхээ эрх ашгийг хамгаалан ажиллах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант оны 1 дүгээр сараас бүтцийн өөрчлөлт хийгдэж Нутгийн удирдлага, зохион байгуулалт, Хяналт шинжилгээ, олон нийттэй харилцах гэсэн 2 хэлтэстэй болсон байна. Удирдах албан тушаал 4, гүйцэтгэх албан тушаал 8, үйлчилгээний ажилтан 2, нийт 14 орон тооны бүтэц, зохион байгуулалтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна..

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт боловсруулж аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дугаар тушаалаар баталж үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134.9 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	7335.5	7335.5	
Үндсэн хөрөнгө	15807.1	43454.2	27647.1
Нийт хөрөнгө	23142.6	50787.7	27647.1
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23142.6	50787.7	27647.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	23142.6	50787.7	27647.1

Мөнгөн хөрөнгө, авлага, өглөг данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Тайланд онд 94.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 43.4 сая төгрөг болж 27.6 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 16.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 2.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч, Аймгийн ИТХ-ын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 157 дугаар тогтоолын дагуу 3.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, элэгдлийн хугацаа нь дууссан 141.0 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг дахин үнэлж 22.2 сая төгрөгөөр бүртгэсэн байна. Үүнд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 130.0 сая төгрөгийн анхны өртөгтэй автомашиныг 20.0 сая төгрөгөөр, 11.0 сая төгрөгийн анхны өртөгтэй тоног төхөөрөмжийг 2.2 сая төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгөд 13.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 27.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 27.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,109.1 сая төгрөгөөр, зарлагыг 1,109.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагын 2023 оны төсвийг хүргүүлсэн саналаас 583.1 сая төгрөгөөр бууруулж, 526.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор 128.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 654.1 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Үүнд: цалингийн зардлыг 60.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 60.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгожээ. Төрийн албан хаагчдын цалин 2023 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 654.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж зарцуулахаар байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 654.1 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 653.9 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна. Оны эцэст 246.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	ОН-ын өөрөө удирд ёсны байгуул				
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	455,601,100	455,601,100	-246.5	99.96
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийл	198,528,000	198,528,000		100%
	Дүн	654,129,100	653,882,621	-246.5	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 651.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч цагаатгалын нөхөн олговорт зарцуулж, бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 94.0 сая төгрөгийн материал, 16.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, ~~дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл~~ нар хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,310.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд төсөвт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 34 шалгуур үзүүлэлтээс тус байгууллагад хамааралтай эрсдэлүүдэд горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгаж үзэхэд төсвийн хөрөнгөөр 16.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй, нормын хувцас зөөлөн эдлэлийн данснаас 1.0 сая төгрөгөөр төлөөлөгч нарт хүрэм худалдан авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж ашиглах талаар 1 зөвлөмж, 42.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгсөн байна. Зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг давтан шалгаж үзэхэд хэрэгжилтийг хангуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	42,935.5	2	42,935.5	100%
Зөвлөмж	1		1		100%
Нийт дүн	3	42,935.5	3	42,935.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд төсвийн зарцуулалт, нэмэлт төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16357.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад, 16357.8 мянган төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланд 246.5 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй, бусад бараа үйлчилгээний зардлаас хөрөнгө худалдан авсан зардлын гүйцэтгэлийг 16111.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.

Аудитаар нийтдээ 87,751.0 мянган төгрөгийн зөрчил² илэрч 17,135.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 70,615.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 17,135.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 16,111.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй, нормын хувцас зөөлөн эдлэлийн данснаас 1024.0 мянган төгрөгөөр төлөөлөгч нарт хүрэм худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Цалингийн зардлаас ажилтнуудад 21,000.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Бичиг хэргийн материалд 5.1 мянган, аж ахуйн материалд 7,330.4 мянган төгрөгийн материал бүртгэлтэй байгаа боловч бодитоор байхгүй, нярвын бараа материалын тайлан гаргаж тооцоо хийгээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүнгээр тооцоо хийж, шийдвэрлээгүй байна. Мөн цалингийн системээр сар бүр гаргасан цалингийн цэсийн бүрдүүлэлт, баримтжуулалт хангалтгүй хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавартай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бичиг хэрэг, аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй, бодитоор байхгүй 7,335.5 мянган төгрөгийн материалын асуудлыг шийдвэрлэх, нярвын бараа материалын тайланг сар бүр гаргаж тооцоо хийх, цалингийн цэсийг зохих журмаар гаргаж баримтжуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг мөрдөж ажиллах.

3. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 157 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 130.0 сая төгрөгийн анхны өртөгтэй Ланд-200 маркийн автомашиныг 20.0 сая төгрөгөөр дахин үнэлж дансанд бүртгэсэн байна. Харин уг автомашинд дахин үнэлснээс хойших 2023 онд нийтдээ 42,280.2 мянган төгрөг сэлбэг тавьсныг хөрөнгийн өртөгт нэмж капиталжуулан бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3 “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 5 дугаар зүйлийн 5.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар, УСНББОУС-17 үндсэн хөрөнгө стандарттай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын Ланд-200 маркийн автомашинд тавьсан 42,280.2 мянган төгрөгийн сэлбэгийн дүнгээр хөрөнгийн өртгийг капиталжуулан бүртгэж, 2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд тусгаж тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТ-д ББҮЗ-аас хөрөнгө худалдан авсан зардлын гүйцэтгэлийг буруу тусгасан	1	16,111.3			1	16,111.3	1	16,111.3				

/мянган төгрөгөөр/

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 246.5 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй	1	246.5			1	246.5	1	246.5				
Дүн	2	16,357.8			2	16,357.8						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.	1	21,000.0					1	21,000.0				
Бараа материалын тооцоотой холбоотой.	1	7,335.5					1	7,335.5				
Автомашинны сэлбэг засварыг капиталжуулж бүртгээгүй.	1	42,280.2					1	42,280.2				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн.	1	17,135.3			1	17,135.3						
Дүн	4	87,751.0			1	17,135.3	1	70,615.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								